



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8 нэрийн, нийт 3,574,224.50 (гурван сая таван зуун далан дөрвөн мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,934,667.35 (нэг сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун жаран долоон төгрөг гучин таван мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бэлгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХӨЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000181
2-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛС ХООРОНДЫН ШУУДАН ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ
СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
Машин тоног төхөөрөмж									
1	Принтер HP Laserjet pro M102A	2020	ш	1	249,900.00	249,900.00	2	74,970.00	74,970.00
2	Хувилагч Epson	2020	ш	1	1,582,000.00	1,582,000.00	5	791,000.00	791,000.00
	Хэсгийн дүн			2		1,831,900.00		865,970.00	865,970.00
Тавилга, эд хогшил									
3	Бичгийн ширээ /wer208/	2018.08.10	ш	1	193,900.00	193,900.00	2	58,170.00	58,170.00
4	Хувцасны шүүгээ /wer208/	2018.08.10	ш	1	200,900.00	200,900.00	2	60,270.00	60,270.00
5	Өндөр модон шүүгээ	2018.08.10	ш	1	409,509.50	409,509.50	2	122,852.85	122,852.85
6	Тумбочик 3-н шургуулгатай-1	2014.06.30	ш	1	158,015.00	158,015.00	2	47,404.50	47,404.50
	Хэсгийн дүн			4		962,324.50		288,697.35	288,697.35
Програм хангамж									
7	Санхүүгийн програм UNICUS	2012.12.15	ш	1	450,000.00	450,000.00	4	450,000.00	450,000.00
8	Архивын програм-ARMS	2020	ш	1	330,000.00	330,000.00	2	330,000.00	330,000.00
	Хэсгийн дүн			2		780,000.00		780,000.00	780,000.00
				8		3,574,224.50		1,934,667.35	1,934,667.35
	Нийт дүн			(найм)		(гурван сая таван зуун далан дөрвөн мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг тавин мөнгө)		(нэг сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун жаран долоон төгрөг гучин таван мөнгө)	(нэг сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун жаран долоон төгрөг гучин таван мөнгө)